



**НИЙСЛЭЛИЙН
СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 1574


Улаанбаатар хот

**Нийслэлийн эмэгтэй сагсан бөмбөгчдийн
тэмцээн зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэлийн эмэгтэй сагсан бөмбөгчдийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 10 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 3.000.000 /Гурван сая/ төгрөгийг Нийслэлийн спортын хорооны Спортын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спортын хөгжлийн хэлтэс /С.Саранцэцэг/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Спортын хорооны даргын
2019 оны 10 сарын 12-ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт



Нийслэлийн эмэгтэй сагсан бөмбөгчдийн
тэмцээн зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Шүүгчдийн ажлын зардал: 15 хүн x 2 өдөр x 40.000 төг = 1.200.000 төг	1.200.000
2.	Медаль: 55ш x 20.000 төг = 1.100.000 төг	1.100.000
3.	Шилдэг тоглогч: 1. Шилдэг довтлогч-140.000 төг 2. Шилдэг хамгаалагч-140.000 төг 3. Шилдэг холбон тоглогч-140.000 төг 4. Шилдэг хүчний тоглогч-140.000 төг 5. Шилдэг төвийн тоглогч -140.000 төг	700.000
Дүн:		3.000.000